

**МОНГОЛ УЛСЫН
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо /цаашид ХХЗХ гэх/-ноос тайлангийн хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны Дарга /буюу Ерөнхий менежер/ болон Монгол Улсын Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагчтай/ нарын хооронд 2009 онд байгуулсан үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөт болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд дараахь томоохон арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэв.

Нэг. Төлөвлөгөөт ажил, арга хэмжээний хүрээнд:

1.1. УИХ, Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны шийдвэр, холбогдох дүрэм, журам боловсруулах талаар.

- ❖ Тайлангийн хугацаанд Харилцаа холбооны зохицуулах хорооны ээлжит 14, ээлжит бус 2 удаагийн хуралдаанаар мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох дүрэм журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл сунгах, олгох, цуцлах зэрэг нийт 100 гаруй дүгнэлт, асуудлыг боловсруулан хэлэлцүүлж нийтдээ Хорооны хуралдааны 66 тогтоолыг гаргалаа. Хорооны хуралдааны тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тухай бүр сар сараар гаргаж, биелэлтийг гарган удирдлагад танилцуулан ажиллаж байна /Хавсралт 3. ХХЗХ-ны 2009 оны хуралдааны тогтоол, шийдвэрийн судалгаа/.
- ❖ ХХЗХ-ны Дарга болон Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагчтай/ нарын хооронд 2009 онд байгуулах үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээ, ХХЗХ-ны санхүүгийн төсвийн төслийг тус тус боловсруулан ЗГХЭГ-т 2009 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/26 тоотоор Ерөнхий сайдад хүргүүлэн баталгаажуулав.
- ❖ “ХХЗХ-ны Дарга болон Ерөнхий сайдын хооронд байгуулсан 2008 оны гэрээний биелэлт”-ийг Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 48 дугаар тогтоолоор баталж, 2008 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу боловсруулан бэлтгэж, ЗГХЭГ-т хүргүүлсэн болно.
- ❖ Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтын хэрэгжилт /Хавсралт-1/, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолын хэрэгжилт (Монгол Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох үндэсний хөтөлбөр)-ийн тайланг нэгтгэн гаргаж, ЗГХЭГ болон МШХХТГ-т тус тус хүргүүлэв /Хавсралт-2/.
- ❖ Хууль зүй дотоод хэргийн яам, Мэдээлэл шуудан, харилцаа холбоо, технологийн газраас боловсруулж буй “Харилцаа холбооны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл, “Мэдээллийн технологийн тухай” багц хуулийн төсөлд ХХЗХ-ны саналыг боловсруулан ажлын хэсэгт өглөө.
- ❖ Тагнуулын ерөнхий газраас боловсруулан УИХ-д өргөн барьсан “Харилцаа холбооны тухай хууль”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, УИХ-ын гишүүн Н.Батбаяраас санаачилсан Өрсөлдөөний тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулиудад

- нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл, Шуудангийн тухай хуульд БНҮҮ-ийн талаархи нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд тус Хорооны санал дүгнэлтийг албан тоотоор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно.
- ❖ Шуудангийн тухай Монгол Улсын хуулийн шинэчилсэн найруулгын 17-р зүйлийн дагуу үндсэн сүлжээ эзэмшигчийн шуудангийн үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг боловсруулан холбогдох яам, газруудад хүргүүлэн шийдвэрлүүлэв.
 - ❖ Тус хорооны 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах нэгдсэн төлөвлөгөөний дагуу алба бүрээр улирал, эхний хагас жил, жилийн төлөвлөгөөний задаргааг гарган хяналт тавьж, холбогдох тайлан мэдээллээр удирдлагыг ханган ажиллав.
 - ❖ ХХЗХ-ноос “Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо технологийн салбар-2009: Хямралтыг гэтлэх арга зам” сэдэвт дугуй ширээний уулзалт, ярилцлагыг 2009 оны 2 дугаар сарын 5-ний өдөр МШХХТГ-тай хамтран зохион байгуулав. Уг уулзалтанд ЗГХЭГ, МШХХТГ, ХХЗХ, салбарт үйл ажиллагаа явуулдаг МХС ХХК, МЦХ ХК, Монгол шуудан ХХК, суурин болон үүрэн холбооны томоохон компаниудын удирдлага, төлөөлөл оролцлоо. Дэлхийн эдийн засгийн хямрал Монгол Улсын эдийн засаг болон ялангуяа МХХТ-ийн салбарт хэрхэн нөлөөлөх төсөөлөл, гарч болох үр дагавар, түүнийг даван туулах арга замууд, хэрэгжүүлэх хувилбар, хямралыг даван туулахад салбарын үйлчилгээг, хэрэглээг давуу тал болгон ашиглах зэрэг асуудлыг хөндөн ярилцаж зөвлөмж гаргалаа.
 - ❖ ХХЗХ-ны хуралдаанаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2008-2012 оны үйл ажиллагааны чиглэл, стратеги” боловсруулах ажлын хэсгийг 2009 оны 113 тоот Даргын тушаалаар байгуулсан ба баримт бичгийн төслийг боловсруулан Даргын зөвлөлийн хурал, ХХЗХорооны хуралдаанд тус тус хэлэлцүүлэн 2009 оны 40 дүгээр тогтоолын хавсралтаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.
 - ❖ Үндэсний радио давтамжийн хяналтыг шинэчлэх төслийг бүрэн хэрэгжүүлж, орчин үеийн радио давтамжийн хяналт, хэмжилтийн тоноглол бүхий суурин, явуулын, зөөврийн тоног төхөөрөмжтэй Үндэсний радио давтамжийн хяналтын тогтолцоог анх удаа Монгол Улсад бий болгов. Монгол Улсад ашиглагдаж буй давтамжийн зурвасыг бүрэн хэмжээгээр хянах боломжийг бүрдүүллээ.
 - ❖ Монгол Улсын Засгийн 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгож бэхжүүлэх”, “Орон зайн мэдээллийн санд тулгуурлсан зөөлөн дэд бүтцийг бий болгож, төрийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх” зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Хаягжилтын нэгдсэн систем”, “Иргэний ухаалаг үнэмлэх” төслийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд тусгах тухай төсөл, хуулийн үзэл баримтлал болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг МШХХТГ-тай хамтран боловсруулж, Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягаас өгсөн удирдамжийн дагуу уг асуудлыг 2009 оны 2 дугаар сард Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Түүнчлэн уг асуудлаар “Эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга, төсөвт өртөг, хөрөнгө, санхүүжилт, хэрэгжүүлэх хуваарийн төслийг тус тус боловсруулан ЗГХЭГ, ХЗДХЯ, МШХХТГ-т хүргүүлсэн болно.
 - ❖ Хорооны Даргын Зөвлөлийн хуралдааныг нийтдээ 9 удаа зохион байгуулж, Даргын 7 хоног дутмын ээлжит шуурхай зөвлөгөөний 50 гаруй удаагийн дарга, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаварын мэдээ, биелэлтийг тухай бүр гаргаж, хэрэгжилтийг танилцуулан тайлагнах арга хэмжээг авч ажиллалаа

- ❖ Удирдлагаас өгсөн удирдамж чиглэл, албадаас ирүүлсэн саналыг үндэслэн Хорооны Даргын зөвлөлийн хуралдааныг 9 удаа зохион байгуулан нийтдээ 40 гаруй асуудлыг хэлэлцэж, холбогдох тэмдэглэл гарган шийдвэрлэв.
- ❖ Тайлангийн хугацаанд ХХЗХ-ны Даргын 198 тушаалын төслийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, иргэд, аж ахуйн нэгжтэй байгуулах 20 гаруй гэрээний төсөл боловсруулж, байгууллага хоорондын 40 гаруй гэрээний хууль эрх зүйн үндэслэлийг хянав.
- ❖ Тайлангийн хугацаанд ХХЗХ-ны ажилтан, ажиллагсдын ажлын байрны үндсэн зорилгыг шинэчлэн тодорхойлж, ажлын байрны тодорхойлолтыг Даргын тушаалаар батлан хэрэгжүүлж ирлээ.
- ❖ Хорооны үндсэн эд хөрөнгийн тооллого хийж, үр дүнг Даргын зөвлөл, ХХЗХ-ны хуралд танилцуулан холбогдох удирдамж чиглэл авч хэрэгжүүлсэн.
- ❖ ХХЗХ-ноос 2009 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, салбарын зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сурталчилах зорилгоор “Контент буюу агуулгын бизнесын чиг хандлага, боломжууд”, “Дараа үеийн мэдээлэл, холбооны сүлжээ, түүнд шилжих хандлага”, “Шуудан-Стандарт 2009”, “Мэдээлэл, харилцаа холбооны олон улсын эрдэм шинжилгээний бага хурал-2009 (ICICT-2009)”, “Өртөг нэмэгдүүлсэн мэдээллийн лавлах үйлчилгээний зохицуулалт”, “Ази, номхон далайн орнуудын хөдөө орон нутагт мэдээлэл түгээх, зохицуулалтын туршлага”, “Мэдээлэл, холбооны сүлжээний нөхцөл шаардлагыг шинэчилэх нь”, “Кабелийн телевизийн нөхцөл, шаардлагыг шинэчилэх хэлэцүүлэг” зэрэг сэдэвт хэлэлцүүлэг, уулзалт, семинарыг тус тус зохион байгуулсан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид, иргэдэд үйл ажиллагааг сурталчилах, төсөл хэрэгжүүлэгчтэй үйл ажиллагаа уялдуулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.
- ❖ Хөдөө орон нутагт мэдээлэл, харилцаа холбоо, шуудан, радио телевизийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, Хорооны орон нутгийн төлөөлөгч нарын үйл ажиллагаатай танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, салбарын зохицуулалтын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор 2009 оны 9 сарын 17-18-ны өдрүүдэд Баруун бүсийн “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын зохицуулалт” сэдэвт семинарыг Ховд аймгийн төвд зохион байгуулсан нь үр дүнтэй ажил боллоо. Семинарт МШХХТГ, МХЕГ, орон нутгийн төр, захиргааны байгууллагын төлөөлөгчид, Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий аймгуудын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөлөл зэрэг нийт 120 гаруй зочид төлөөлөгчид хамрагдлаа.
- ❖ Сүлжээ хоорондын дотоодын харилцан холболтод газар зүйн ялгаваргүй төлбөрийг 2010 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөх, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээ хоорондын харилцан холболтын орлого хуваарилах зарчмыг 2009 оны 61 тоот тогтоолоор хянан батлуулав. Мөн орон нутагт хотын доторхи харилцан холболтын зааглах цэгийг үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид үүсгээгүйгээс бий болсон төлбөрийн асуудлыг шийдвэрлэн зохицуулалтыг хийлээ. Уг зарчмыг хэрэгжүүлснээр үүрэн холбооны хэрэглэгч Монгол Улсын хаанаас ч ярьсан ижил үнэ тарифаар үйлчлүүлэх боломжтой болно.
- ❖ Тайлангийн хугацаанд мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, радио давтамж, шуудангийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, тусгай дугаарын талаар ирүүлсэн 250 гаруй иргэд, компани, байгууллагын материалыг хүлээн авч, Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хууль, “Радио долгионы тухай” хууль, “Шуудангийн тухай” хууль, холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж,

техник, технологийн судалгаа, давтамжийн нөөц, төлөвлөлтийн хуваарь, эдийн засгийн чадавхи, үр дүнгийн үнэлгээг хийж, газар дээр нь танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Нийтдээ 150 гаруй удаа өргөдөл гаргагчийн хүсэлтээр радио давтамжийн зурвасын ашиглалт, радио долгионы харилцан нөлөөлөл үүсэх магадлалтай эсэхийг тодорхойлох, шинэ техник технологи нэвтрүүлэх талаар судалгааг хийж, саналаа боловсруулав. Үүнд: Шинээр 123 ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, хавсралт гэрээг байгуулсан. Тусгай зөвшөөрөл сунгуулах тухай 44 хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэж, гэрээ болон гэрчилгээг сунгав. Мэдээлэл, лавлагааны чиглэлээр тусгай дугаарын зөвшөөрөл хүсч ирүүлсэн материалыг судлан боловсруулж 18 тусгай дугаарыг шинээр олгож, тусгай дугаарын 12 зөвшөөрлийн хугацааг сунгаж гэрчилгээ олгон гэрээ байгууллаа. Интернэтийн төв байгуулахаар иргэд, байгууллагаас ирүүлсэн материал хүсэлтийг судлан 10 гаруй байгууллага, компанид бүртгэлийн гэрчилгээг олголоо. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох тухай бүрд тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд бүртгэж, бүртгэлийг тухай бүр программд оруулан хөтөлсөн болно. /Хавсралт-4. Мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн судалгаа-2009 он/.

- ❖ Тус хорооноос олгогдсон 15 тусгай зөвшөөрөл, бүртгэлийн 34 гэрчилгээ эзэшигчид гэрээний хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах асуудлыг ХХЗХ-ны хуралдаанд танилцуулан тус хорооны тогтоолоор, мэдээллийн лавлах үйлчилгээний зориулалтаар олгогдсон 12 тусгай дугаар ашиглах эрхийн хугацаа дууссан, зохицуулалтын үйлчилгээний төлбөр төлөөгүй, үйл ажиллагаа явуулаагүй зэрэг шалгалтын дүгнэлтийг үндэслэн Даргын тушаалаар тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн.
- ❖ Ирүүлсэн материалыг судлан 18 тусгай дугаарыг шинээр олгож, тусгай дугаарын 12 зөвшөөрлийн хугацааг сунгаж гэрчилгээ олгон гэрээ байгуулав.
- ❖ Нийт интернэтийн төв байгуулахаар иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг судлан 10 гаруй байгууллага, компанид бүртгэлийн гэрчилгээ олголоо.
- ❖ Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох тухай бүрд тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд бүртгэж, бүртгэлийг тухай бүр программд оруулан хөтөлсөн болно.
- ❖ Шуудангийн чиглэлээр нийт 7 аж ахуйн нэгжийн “Б” ангилалын тусгай зөвшөөрлийг цуцалж, 13 аж ахуйн нэгжид шинээр “Б” ангилалын тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд 8 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ХХЗХ-ны хуралдаанд оруулж шийдвэрлэв.
- ❖ “Монгол Улсад интернэт протокол ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалт”, “Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэх, “Хот, хот хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинээр боловсруулан ХХЗХ-ны 2009 оны 26-р тогтоолоор тус тус батлуулав. Эдгээр батлагдсан баримт бичгүүдийн талаар үйлчилгээ эрхлэгчид нарт танилцуулах, гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулав.
- ❖ Телевизийн өргөн нэвтрүүлэг, кабелийн телевиз, Ай Пи ТВ, хөдөлгөөнт ТВ зэрэг телевизийн бүх төрлийн дамжуулалтын талаарх олон улсын туршлага болон Монголын зах зээлийн орчин, хандлагыг судалж үзсэний үндсэн дээр "Мултимедиа үйлчилгээг Ай Пи ТВ, хөдөлгөөнт ТВ-ээр хүргэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага", түүнчлэн телевизийн өргөн нэвтрүүлгийн болон кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагуудыг шинэчлэн боловсруулж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэв.

- ❖ Богино үсэг мэдээ буюу SMS үйлчилгээний зохицуулалтын талаарх шийдвэрийг гаргаснаар үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчидтэй уг чиглэлээр хамтран ажиллах Санамж бичиг байгуулав. Улмаар уг үйлчилгээний зохицуулалтын нэгдсэн журмыг үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран боловсруулан Хорооны хуралдаанаар шийдвэрлэв. Энэхүү үйлчилгээнд хийсэн зохицуулалтын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийсэн болно. Уг зохицуулалтын үр дүнд үүрэн телефоны үйлчлэгчид нэг өргөдөл гаргачид нэг ижил тусгай мессежийн дугаарыг ижил үнэ тарифаар нэгэн зэрэг олгодог зарчимд шилжүүлсэн.
- ❖ ХХЗХ-ноос байгуулсан "Интернэтэд суурилсан телефон ярианы үйлчилгээний бодлого, зохицуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох ажлын хэсэг"-ийн хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, олон улсын туршлага зэргийг судлан үйлчилгээ эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэг явуулсан ба ажлын хэсгээс уг зах зээлд чөлөөтэй өрсөлдөөн оруулах, нөхцөл шаардлагыг сайжруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийлээ. Ажлын хэсгийн дүгнэлтийг ХХЗХ-ны 2009 оны 7 дугаар сарын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлэв.
- ❖ ХХЗХ-ны Даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан Улаанбаатар хотод телевиз, кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, техник, технологийн шинэчлэл хийгдэж байгаа байдал, цаашдын чиг хандлага зэргийг судлан Монгол Улсад телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжих бэлэн байдал, телевизийн зах зээлд өрсөлдөөний зохицуулалт хийх нөхцөл, шаардлага зэргийг тодорхойлох зорилгоор нийтдээ 13 эфирийн, 7 кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн байдалтай танилцаж, шалгалт хэмжилтийг 2009 оны 4 дүгээр улиралд зохион байгуулав. Ажлын хэсгээс энэ зах зээлд өрсөлдөөний зохицуулалт шаардлагатай байгаа, өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын баримт бичиг, телевиз болон кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг шинэчилэн боловсруулах шаардлагатай гэж дүгнэлээ. Энэ арга хэмжээний хүрээнд 2009 оны 11, 12 дугаар сард “Мэдээлэл, холбооны сүлжээний нөхцөл шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах”, “Кабелийн телевизийн нөхцөл, шаардлагад нэмэлт өөрчлөлт” баримт бичгийг боловсруулан Хорооны ДЗХ-нд танилцуулан, төрийн байгууллага болон үйлчилгээ эрхлэгчидтэй хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулав.
- ❖ Дэлхийн банкны санхүүжилтээр алслагдсан малчдыг холбоожуулах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын 76 сумын 152 цэгт сансарын холбооны хиймэл дагуул ашиглан нийтэд үйлчлэх холбооны цэгийг ашиглалтанд оруулав.
- ❖ Интернэтийн үйлчилгээний үнэ тарифыг бууруулах зорилгоор олон улсын интернэтийн урсгал, гарцыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч байна.
- ❖ ОУЦХБ ба АХБ-наас хэрэгжүүлэхээр тохиролцсон “Хөдөө орон нутгийн МХТ-ийн бодлого, чадавхийг бүрдүүлэх ба мэдээлэл түгээх” (Rural ICT Policy Advocacy, Capacity Building and Knowledge Sharing) төслийн багтай 2009 оны 6 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд хамтран ажиллаж, төслийг хэрэгжүүлэхэд ХХЗХ-ны оролцооны талаар хэлэлцэн эцэслэн тохиролцов. Төслийн хүрээнд 2009 оны 10 дугаар сард ОУЦХБ, АХБ, МШХХТГ-тай хамтран семинар зохион байгуулав.
- ❖ ХХЗХ-ноос зип кодыг төр, хувийн хэвшил, иргэдэд сурталчилах, хэрэглээг хэвшүүлэх зорилгоор өдөр дутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол булан нээж аймаг бүрээр шуудангийн зип кодын хуваарилалт, зураглалыг гарган сурталчилах арга хэмжээг зохион байгуулав. Шуудангийн зип кодоод хамрагдах багийн жагсаалтыг шинэчилэн гаргаж дуусгалаа.

- ❖ Шуудангийн тусгай зөвшөөрлийн гэрээнд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ явуулахыг хориглох тухай нэмэлт заалт оруулан тусгай зөвшөөрлийн гэрээг шинэчлэх ажлыг хийлээ.
- ❖ Шуудан-Стандарт 2009 сэдэвт шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн сургалт семинарыг 2009 оны 6 дугаар сард зохион байгуулав. Энэ үеэр үйлчилгээний өртөг тооцоох аргачлал, тариф тогтоох аргачлалын талаар зөвлөмж өгч, шуудангийн мэдээ тайланг гаргах маягтын зааврыг танилцуулсан болно.
- ❖ ХХЗХ-ноос 2009 оны 9 дүгээр сард Ховд хотод зохион байгуулсан Баруун бүсийн уулзалт, семинарын өмнө тус хорооноос газар дээр шалгалт хийх 2 ажлын хэсэг томилон ажиллуулж, бүсийн 5 аймаг, 13 сум, 3 багийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон бүх нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хамрах хүрээтэй танилцан холбогдох хэмжилтийг гүйцэтгэж, семинарын үеэр шалгалтын дүнг танилцуулсан. Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ДЗХ-аар хэлэлцүүлэн оролцогч байгууллагуудад албан тоотой хүргүүлсэн болно.
- ❖ Тайлангийн хугацаанд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 90 гаруй байгууллага, хувь хүний материалыг судлан санал дүгнэлт боловсруулж, Хорооны хуралдаанд хэлэлцүүлэн 44 иргэн, компани, байгууллагад радио долгионы тусгай зөвшөөрлийн эрхийг шинээр олголоо. Эдгээрээс 4 тусгай зөвшөөрлийн эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу уралдаант шалгаруулалтын хэлбэрээр зохион байгуулан олгосон болно.
- ❖ Радио давтамж ашиглах эрхийн бичиг шинээр эзэмшихээр хүсэлт гаргасан 130 гаруй иргэн, байгууллагын материалтай танилцан Хорооны даргын тушаал гаргуулан 100 эрхийн бичгийг шинээр олголоо. Радио давтамж ашиглах эрхийн бичиг 85 холбогдох журам, дүрмийн хүрээнд сунгаж, шийдвэрлэсэн.
- ❖ ХХЗХ-ны хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 15 байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан болон радио давтамжийн төлбөрийн зөрчилтэй буюу холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангаагүй нийт 33 тусгай зөвшөөрөл, 86 эрхийн бичгийг цуцлуулах арга хэмжээ авч ажиллав.
- ❖ Радио давтамж ашиглах эрхийн бичгийн улсын бүртгэлийг дахин хянаж, 2008 оноос хойш хугацаанд сунгалт хийгдээгүй, албан тоотой анхааруулсан боловч хүсэлт ирүүлээгүй 30 эрхийн бичгийг цуцалсан ба хугацаа дууссан 141 иргэн, байгууллагад албан тоотой мэдэгдэл хүргүүлж, анхаарулга өглөө.
- ❖ Үүрэн холбооны 3 дахь үе буюу 3G технологи, үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр үүрэн холбооны салбарт дэвшил гарч, мэдээлэл холбооны шинэ төрлийн үйлчилгээ, хэрэглээг хэрэглэгчид хүртэх боломжийг бүрдүүлэв. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч оператор компаниуд 3G технологи нэвтрүүлэх шилжилт, шинэчлэлтийг хийж байна.
- ❖ Монгол Улсад урт, дунд, богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн системийг тоон системд шилжүүлэх шилжилтийн үе шатыг тодорхойлох, технологийн шийдлийг багтаасан хөтөлбөр болон арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг ХХЗХ-ны Даргын тушаалаар салбарын мэргэжилтнүүдийг оролцуулан байгуулсан. Ажлын хэсгээс уг хөтөлбөр, ажлын төлөвлөгөөг боловсруулан 2009 оны 6 дугаар сард Хорооны удирдлага, МШХХТГ-т тус тус танилцуулсан ба холбогдох арга хэмжээг 2010 онд хэрэгжүүлэхээр төлөвлөв.

- ❖ Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан шийдвэр, зөвлөмжинд үндэслэн Үндэсний радио давтамжийн талаар 2009-2012 он хүртэл баримтлах давтамжийн зурвасын төлөвлөлтийн стратегийг шинэчлэн боловсруулсан болно.
- ❖ ОУЦХБ-д Монгол Улсын радио давтамж хуваарилалтыг бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, бүртгэлд бүртгүүлэх эрхийн зөвшөөрлийг авч чадсан ба холбогдох программ хангамжуудыг худалдан авч, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 23 FM радио станц, 13 телевизийн тухай өгөгдлийг Олон улсын мастер бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг авлаа.
- ❖ Радио давтамжийн хуваарилалтын төлөвлөлтөнд сансрын холбоо, телевизийн өргөн нэвтрүүлэг, хэт богино долгионы FM радио, хувийн хэрэглээ ба бусад төрлийн давтамжийн зурвасын шаардлагатай өөрчлөлтийг тухай бүрд тусган ажилласан.
- ❖ “Зохицуулалтын чиглэл”-ийг баримтлан Утасгүй холболтын технологийг нэвтрүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 3.5 ГГц давтамжийн зурваст тусгай зөвшөөрөл олгох тендерийн нөхцөл, шаардлагыг боловсруулан, сонгон шалгаруулалтыг 30 хоногийн хугацаатай зохион байгуулж, үр дүнг ХХЗХ-ны хуралдаанд танилцуулсан. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2,5 болон 3.5 ГГц давтамжийн зурваст өргөн зурвасын утасгүй интернетийн үйлчилгээний төсөл шалгаруулах нөхцөл, шаардлагыг холбогдох албадтай хамтран боловсруулж, төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан үр дүнг Хорооны хуралдаанд танилцуулав.
- ❖ Утасгүй холболтын шинэ үеийн технологийг нэвтрүүлэх зорилгоор Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт өргөн зурвасын утасгүй интернетийн үйлчилгээнд өрсөлдөөн оруулах, радио давтамжийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2.5 ГГц-ийн давтамжийн зурваст судалгаа хийж шинэ төрлийн үйлчилгээ оруулах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд уг давтамжийн зурваст Өргөн зурвасын утасгүй интернетийн үйлчилгээ (Wi-Max)-г нэвтрүүлэх зорилгоор 2 үйлчилгээ эрхлэгчийг шалгаруулан гэрээг байгууллаа.
- ❖ “Радио давтамжийн төлбөрийн журам”-д өөрчлөлт хийх саналыг боловсруулан ХХЗХ-ны хуралдаанд танилцуулан, гишүүдийн саналыг тусган шинэчилэн өөрчлөв. Хөдөлгөөнт холбоо, өргөн зурвасын утасгүй холбооны шинэ үеийн технологитой нэвтэрч байгаатай холбогдуулан зарим төлбөрийг төгрөгт шилжүүлсэн ба шинэчилсэн хэлбэрээр төлбөрийг тогтоон хэрэгжүүлж байна.
- ❖ Монгол Улсад 3 дахь үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэх сонгон шалгаруулалт, эрх олгох үйл ажиллагааг зохион байгуулсантай холбогдуулан гэрээний загварт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан шийдвэрлүүлэв.
- ❖ Тусгай хэрэглээний байгууллагуудын радио давтамжийн зурвасын ашиглалтанд судалгаа шинжилгээ хийж, 440-450 МГц-ийн давтамжийн зурвасын ашиглалтанд өөрчлөлт оруулж, ХХЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.
- ❖ Нийтийн хэрэглээний давтамжийн зурваст 340-350 МГц-ийн давтамжийн зурваст нийтийн тусгайлсан хэрэглээний зурвасыг хуваарилах, техникийн шалгуурыг боловсруулан ХХЗХ-ны 2009 оны 6 дугаар сарын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна.
- ❖ ОУЦХБ /ITU/-аас гаргасан SMS4DC программыг радио давтамжийн хяналтын болон хэмжилтийн өдөр тутмын ажилд ашиглах зорилгоор өгөгдлийг оруулж байгаа бөгөөд программын хэлийг Монгол хэл дээр бичдэг, ашиглан ажилладаг болгож өөрчлөх арга хэмжээг хэрэгжүүлэв.
- ❖ Улаанбаатар хотод тоон телевизийн газрын сүлжээ /CMMR, DVB/-г нэвтрүүлэх туршилтын төсөл шалгаруулалтаар үйлчилгээ эрхлэгчийг сонгох уралдаант шалгаруулалтыг зарлах, радио давтамжийн төлөвлөлтийг тооцоолох, техникийн

- нөхцөл, шаардлагыг боловсруулах ажлуудыг гүйцэтгэн ХХЗХ-ны хуралдаанд танилцуулан сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчдод зөвшөөрөл олгосон болно.
- ❖ Давтамжийн зурвасын ашиглалтыг сайжруулах зорилгоор 174-240 МГц-ийн давтамжийн зурваст шинэ төрлийн тоон систем /DMB/-ийг нэвтрүүлэх боломжийг судлан, давтамжийн төлөвлөлтийг шинээр тооцоолон гаргаж холбооны салбарын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн хөдөлгөөнт тоон телевизийн T-DMB технологид 182-190 МГц давтамжийн зурвасыг олгохоор шийдвэрлэсэн.
 - ❖ Дэлхийн банкны дэмжлэгээр Үндэсний радио давтамжийн хяналтыг шинэчлэх төслийг бүрэн хэрэгжүүлж, орчин үеийн радио давтамжийн хяналт, хэмжилтийн тоноглол бүхий суурин, явуулын, зөөврийн тоног төхөөрөмжтэй Үндэсний радио давтамжийн хяналтын тогтолцоог анх удаа Монгол Улсад бий болгов. Монгол Улсад ашиглагдаж буй давтамжийн зурвасыг бүрэн хэмжээгээр хянах боломжийг бүрдүүллээ. Үндэсний радио давтамжийн хяналтын тогтолцоог шинэчлэх төслийн хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Үүнд:
 - Радио долгион хяналтын станцын барилгын зураг, төсвийн ажлыг бүрэн дуусгаж, экспертизээр баталгаажуулах, барилгын төсвийг гарган хэрэгжүүлсэн.
 - РДХС-ын тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах, ажлын байрыг бэлтгэх, барилгын засварын ажлуудыг хариуцан зохион байгуулж, засварын ажлуудын гүйцэтгэлийг хянаж, хүлээж авсан;
 - Төслийн хүрээнд инженер техникийн ажилтнуудыг Изриаль улсад хяналтын төхөөрөмж дээр ажиллах дадлага эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Мөн төслийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлэгч компани дээр тоног төхөөрөмж үйлдэрлэлт, баталгаажуулалтын явцтай танилцах болон үйлдэрлэлийн тест, хэмжилтийн ажиллагааг зохион байгууллаа.
 - ДЗХ-аар РДХС-ийн бүтэц, орон тоог тогтоох тухай асуудлыг хэлэлцүүлэх тэмдэглэл гаргуулан хэрэгжүүлж байна.
 - Олон улсын жишигт нийцүүлэн инженер техникийн ажилтнуудад эзэмшүүлэх дадлага сургалтыг 2009 оны 5-р сард зохион байгуулав.
 - Төслийн хүрээнд Радио долгион хянах станцын дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ/эрчим хүчний 2 талын холболтыг бий болгох, худаг усаар хангах, хяналтын барилгын гадна орчныг гэрэлтүүлэх, гадна орчныг цэвэрлүүлэх г.м./-г ЭЗМЗА-тай хамтран авч хэрэгжүүлсэн.
 - Дэлхийн банкны төслөөр хэрэгжүүлсэн “Радио долгион хяналтыг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж дуусгасан ба төслийн хүрээнд Орбитод байрлах РДХСтанцын байранд тоног төхөөрөмжийг суурилуулсан ба суурилуулалтын дараахь тоног төхөөрөмжийн шалгалтыг хийж, төслийг хүлээн авсан зэрэг болно
 - ❖ Мэдээлэл, холбооны шинэ төрлийн үйлчилгээ болох Ай Пи телевиз, хөдөлгөөнт телевизийн үйлчилгээг Улаанбаатар хотод нэвтрүүлэх сонгон шалгаруулалтыг зарлан тус бүр 2 компанийг сонгон шалгаруулж, ХХЗХ-ны хуралдааны шийдвэрээр тусгай зөвшөөрөл олгов.
 - ❖ Тайлангийн хугацаанд радио долгион хяналтын станцын зөөвөр болон явуулын станцаар Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг сумдад радио давтамжийн ашиглалтын нийт зурваст (9 кГц - 26,5 ГГц) хэмжилт, шалгалт хийж, ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн болно.

- ❖ Тайлант хугацаанд шинээр тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан интернетийн үйлчилгээ эрхлэх 4, холбооны кабель шугамын угсралт суурилуулалтын 50, улс хоорондын шуудангийн үйлчилгээ 21, шуудангийн үйлчилгээг дамжуулан хүргэх үйлчилгээ 1, интернэтэд суурилсан улс хоорондын телефон ярианы үйлчилгээ 3, шуудангийн үйлчилгээ 1, кабелийн телевиз 3 зэрэг үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан 83 байгууллагын санхүүгийн чадавхийг ХХЗХ-ны 2007 оны 68 тоот тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрөл хүсэгчдийн санхүүгийн чадавхийг үнэлэх аргачлал”-ын дагуу хянаж, Хорооны хуралдаанд танилцуулав.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого, эдийн засгийн байдал, зах зээлийн өргөжилт, цар хүрээ, хэрэглээ, өнөөгийн байдал, Монгол Улсад оруулж байгаа хувь нэмрийн талаар 2008 оны жилийн эцэс, 2009 оны эхний хагас жилийн статистик мэдээллүүдийг цуглуулан нэгтгэж мэдээллийн санд нэгтгэж оруулсан.
- ❖ Салбарын үйлчилгээний үнэ тариф, зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд оруулах өөрчлөлт, салбарын эдийн засгийн зохицуулалт, бүх нийтийн үйлчилгээний зэрэг чиглэлээр нийт 14 асуудлыг боловсруулан ХХЗХ-ны хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.
- ❖ Дэлхийн Банкны төслөөр хэрэгжсэн “Малчдад суурин холбооны үйлчилгээ хүргэх” төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулан УИХ-ын хурлын гишүүдэд хүргүүлэн танилцуулав.
- ❖ Улс хоорондын үйлчилгээний зах зээлийн зохицуулалт хийх санал боловсруулахтай холбогдуулан улс хоорондын орох ярианы үйлчилгээ эрхлэгчдийн 2006-2008 оны нийт ачааллын мэдээлэлд үндэслэн тухайн зах зээлийн нийт багтаамж болон эдийн засгийн тооцоо, орох ярианы хяналтын нэгдсэн станцын нээгдсэн хугацаанаас өнөөг хүртэлх орлого, үр дүнгийн тооцоонуудыг хийж судалгааны дүнд дүгнэлт гаргалаа.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаас 2009 оны жилийн үйл ажиллагааны тайланг авахаар 380 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл авах хүснэгт, маягтыг албан бичгийн хамт хүргүүлж тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 100 хувь нь мэдээллээ ирүүлсэн ба 2010 оны эхний улиралд нэгтгэн гаргана.
- ❖ Улс хоорондын яриаг төгсгөх 1 минутын ярианы төлбөрийг төгрөгт шилжүүлэн ХХЗХ-ны 2009 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 11 тоот тогтоолоор батлуулан мөрдүүлж байна.
- ❖ Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн өгөгдөл дамжуулах, байгууллагын дотоод сүлжээний үйлчилгээний зориулалтаар хот хоорондын суваг түрээслэх тарифын үндэслэлийг хянаж, ХХЗХ-ны 2009 оны 12 тоот тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлэв.
- ❖ Дугаарлалтын зохицуулалтанд орсон өөрчлөлттэй холбогдуулан мессеж үйлчилгээний багц дугаарын зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоон ХХЗХ –ны 2009 оны 6 дугаар сарын 26-ний өдрийн 20 тоот тогтоолоор батлуулсан.
- ❖ Улс хоорондын телефон ярианы үйлчилгээнд тавигдах нөхцөл шаардлагад орсон өөрчлөлттэй холбогдуулан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд холбогдох өөрчлөлтийг оруулан ХХЗХ-ны 2009 оны 35 тоот тогтоол, тусгай зөвшөөрлийн ангилалд оруулсан өөрчлөлтийн дагуу “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-д холбогдох өөрчлөлтийг оруулан ХХЗХ-ны 49 тоот тогтоолоор тус тус батлуулсан болно.

- ❖ Сүлжээ хоорондын дотоодын харилцан холболтод газар зүйн ялгаваргүй төлбөрийг 2010 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөх, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээ хоорондын харилцан холболтын орлого хуваарилах зарчмыг 2009 оны 61 тоот тогтоолоор хянан батлуулав. Мөн орон нутагт хотын доторхи харилцан холболтын зааглах цэгийг үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид үүсгээгүйгээс бий болсон төлбөрийн асуудлыг шийдвэрлэн зохицуулалтыг хийлээ. Уг зарчмыг хэрэгжүүлснээр үүрэн холбооны хэрэглэгч Монгол Улсын хаанаас ч ярьсан ижил үнэ тарифаар үйлчлүүлэх боломжтой болно.
- ❖ ХХЗХ-ноос үүрэн телефон холбооны зах зээлийн давамгайлал үйлчлэгч Мобиком ХХК-ийн үйлчилгээний тарифт хяналт тавих, үйлчилгээний өртгийн тооцоог хянах чиглэлээр ажлын хэсэг ажиллуулж, тус компанийн 2009 онд хэрэгжүүлэх хөнгөлөлт урамшууллын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үйлчилгээний үнэ тарифын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өглөө.
- ❖ Мобиком ХХК-иас сүлжээн доторх болон бусад сүлжээ рүү ярих ярианы тарифыг хямдруулахаар ирүүлсэн саналын үндэслэлийг хянаж, холбогдох дүгнэлтийг боловсруулан ХХЗХ-ны хуралдаанд хэлэлцүүлэн 2009 оны 62 тоот тогтоолоор шийдвэрлэв.
- ❖ Суурин телефон холбооны давамгайлал үйлчлэгч МЦХ ХК-ийн хотын доторхи ярианы тарифыг төгрөгт шилжүүлэн шинэчлэн тогтоох, хэрэглэгчийн сарын суурь хураамжийг шинэчилэхээр ирүүлсэн саналыг судлаж, үнэ тарифид зохицуулалт асуудлыг Хорооны хуралдаанд оруулан 2009 оны 64 тоот тогтоолоор батлууллаа.
- ❖ ХХЗХ-ны 2009 оны 14 дүгээр хуралдаанаар сүлжээ хооронд харилцан холболтын газар зүйн ялгаагүй зарчмыг нэвтрүүлэхээр шийдвэрлэв.
- ❖ Үүрэн болон суурин холбооны үйлчилгээ эрхлэгчдийн удирдлагуудтай салбарын зах зээлийн байдал, зохицуулалтын чиг хандлага, учирсан хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, цаашид хамтран ажиллах чиглэлээр уулзалтуудыг зохион байгуулж, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Жи-Мобайл ХХК болон бусад үүрэн холбооны оператор хооронд үүссэн маргааныг Монгол Улсын “Харилцаа холбооны тухай хууль”-ын 9.1.4-т заасан бүрэн эрхийнхээ дагуу харилцан холболт, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн хэвийн үйл ажиллагаанд оруулсан.
- ❖ Сүлжээний харилцан холболтын нийт 26 үндсэн гэрээ, 12 нэмэлт гэрээг бүртгэлжүүлж, дугаар олгон бүртгэлийн санг бүрдүүллээ. Мөн Мобиком ХХК- УБТЗ ХНН, МЦХ ХК-Скайнэтком ХХК, МЦХ ХК- УБТЗ ХНН, Скайтел ХХК-МЦХ ХК, МЦХ ХК-Юнител ХХК хоорондын нийт 5 гэрээг Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журмын дагуу хянаж шинээр бүртгэсэн. Мөн Мобиком ХХК-МЦХ ХК, МЦХ ХК-Жи Мобайл ХХК-иудын хооронд байгуулсан үндсэн болон нэмэлт гэрээнүүдийг журмын дагуу хянаж бүртгэхээс татгалзсан болно.
- ❖ Шуудангийн үйлчлэгч нарын үйл ажиллагаанд нэвтрүүлж эхлээд байгаа тогтмол хэвлэл хүргэлтийн үйлчилгээний шинэчилсэн зарчмын хэрэгжилтийн байдлын судалгааг шуудангийн албатай хамтран хийж үр дүнг танилцуулав.
- ❖ Үндэсний Статистикийн Хорооноос баталсан ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс авдаг Монгол Улсын мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлт, маяганд ОУЦХБ-ын зөвлөмж аргачлалын дагуу зах зээлийн мэдээллийг гаргахад шаардлагатай өөрчлөлтийг оруулан туршилтын журмаар аж ахуйн нэгж байгууллагуудаас саналыг авч, ҮСХ-аар батлуулахаар хүргүүлэв.

- ❖ Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон, цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээний биелэлтэд хяналт хийх ажлын хүрээнд 2009 оны хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон нэмэлт гэрээг бүртгэн хяналт тавьж шинэчлэн бүртгэх ажлыг хийлээ.
- ❖ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу 2009 онд Үүрэн телефон, суурин телефон, Утасгүй суурин, Интернет, Кабель телевиз, Шуудан холбоо, сансрын холбооны үйлчилгээний зах зээлийн давамгайллагч үйлчлэгчийг ШӨХТГ-тай хамтран тодорхойлон ба олон нийтэд зарлав.
- ❖ Үүрэн телефон холбооны зах зээлийн давамгайл үйлчлэгч Мобиком ХХК-ийн үйлчилгээний тарифт хяналт тавих, үйлчилгээний өртгийн тооцоог хянах чиглэлээр ажлын хэсэгт хамтран ажиллаж тус компанийн 2009 онд хэрэгжүүлэх хөнгөлөлт урамшууллын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үйлчилгээний үнэ тарифын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөв.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хийгдэх БНҮҮС-нд шаардлагатай судалгаа шинжилгээг хийж, 2009 онд хэрэгжүүлэх бүх нийтийн үйлчилгээ буюу зайлшгүй шаардлагатай мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний жагсаалтыг боловсруулан, нийтэд мэдээлэх арга хэмжээг авлаа.
- ❖ БНҮҮС-аас нийт 55 сая төгрөгийн нөхөн төлбөртэй Хэнтий аймгийн отрын нутаг Хэрлэн Баян Улаан тосгонд нарны зайн тэжээлийн үүсгүүртэй интернетэд суурилсан IP технологийн раио релейны дамжуулах системийг суурилуулсан ба ашиглалт үйлчилгээг Мэдээлэл Холбооны Сүлжээ компанид хариуцуулан хүлээлгэн өглөө.
- ❖ Бүх Нийтийн Үйлчилгээний Үүргийн сангийн 2008 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж ХХЗХ-ны хуралдаан болон БНҮҮС-ийн Хяналтын зөвлөлд танилцуулан, аудит хийлгэн Засгийн газарт тайлагнаж, нийтэд мэдээлсэн.
- ❖ БНҮҮС-ийн санхүүжилтээр 2008 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн өгөх ажлыг зохион байгуулж, холбогдох хүсэлтийг ТӨХ-нд хүргүүлэн шийдвэрлүүлж, МХС ХХК болон Радио телевизийн сүлжээ УҮГ-т тус тус шилжүүлэн өглөө.
- ❖ БНҮҮСангийн 2008 оны харилцахын гүйлгээний тооцоог Төрийн сантай нийлж, Санхүүгийн тайланг Сангийн Яамаар хянуулан ЗГХЭГазарт 2009 оны 1 сард хүргүүлсэн. БНҮҮСангийн Хяналтын зөвлөлийг 2009 оны 3 сарын 17-ны өдөр хуралдуулсан ба аудит хийсэн тайлан, тайлбар тодруулгыг танилцуулав.
- ❖ Засгийн газрын 2009 оны 151 тоот тогтоолын дагуу ХХЗХ-ны дэргэд ажиллаж байсан БНҮҮС-ийн 3910,5 сая төгрөгийн үлдэгдэл, холбогдох эд хөрөнгийг бүртгэн МШХТГ-т албан ёсоор хүлээлгэн өглөө.
- ❖ “Орон нутагт өгөгдлийн сүлжээний төгсгөлийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах” төслийн гүйцэтгэгч “Бодь электроникс” ХХК-ны гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авах ажлыг зохион байгуулсан.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик, индикатор үзүүлэлтүүдийг олон улсын жишигт нийцүүлэн гаргах ажлын хүрээнд ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж, аргачлалтай уялдуулан Монголын нөхцөлд шууд гаргах боломжтой үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргаж, судалгааны маягтад тусган шинэчилсэн. Мөн "Asian ICT indicator"-ийг гаргадаг аргачлалын дагуу мэдээллийг гаргах ажлыг хийж байгаа ба энэ хүрээнд холбогдох судалгааг 2004-2008 оны байдлаар хийх ажлыг зохион байгуулав.
- ❖ Дэлхийн банкны “Мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн дунд хугацааны үнэлгээний ажлын (ICIDP: World Bank Mid-term Review Mission) хэсэгтэй 2009 оны 6 дугаар сарын 9-24-ны өдрүүдэд хамтран ажиллаж, ХХЗХ-ны хэрэгжүүлж

буй төслүүдийн хэрэгжилт, санхүүжилтийн асуудлаар уулзалт зохион байгуулав. Мөн Дэлхийн банкны ажлын хэсэг, Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран Төв, Дундговь аймгийн Дэлгэрхангай сум, Тарагт, Толь зэрэг баг болон Өмнөговь аймгийн зарим сумдад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн байдалтай газар дээр нь очиж танилцан ажиллаа.

- ❖ Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны мөрийн хөтөлбөр болон “Харилцаа холбооны тухай” Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан батлагдсантай холбогдуулан МШХХТГ-т холбогдох мэдээлэл, материалыг нэгтгэн албан тоотоор хүргүүлж хамтран ажиллав.
- ❖ “Цахим Монгол” хөтөлбөрт мэдээлэл, харилцаа холбооны зохицуулалтын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг маягтын дагуу улирал, хагас жилээр нэгтгэн гаргаж ЗГХЭГ, МШХХТГ-т тус тус хүргүүлсэн болно.
- ❖ ХХЗХ-ны Оны ном-2008 (CRC Annual book-2008) боловсруулах ажлын хэсэг 2009 оны 29 тоот тушаалаар байгуулан ажиллуулж, тус номын Англи хэл дээрх хувилбарыг товхимол ном болгон 125ш хэвлүүлж, албан хэрэгцээнд ашигласан болно. Уг товхимолыг олон улс, бүс нутгийн олон улсын байгууллага, Монгол Улсад суугаа гадаадын элчин сайдын яам, байгууллагуудад хүргүүлэн үйл ажиллагаагаа сурталчилах арг хэмжээг авлаа.
- ❖ Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг Даргын тушаалаар байгуулан Хорооны архив, албан хэрэг хөтлөлтийг дүгнэж, зөвлөмж бүхий дүгнэлтийг ДЗХ-д танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав. Хорооны архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах ажлын хүрээнд “Архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулан хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд байгууллагын “Архивын ажлын журам”-ыг боловсруулан Даргын тушаалаар батлуулан мөрдлөө.
- ❖ Хорооны 2008 оны санхүүгийн тайлан балансад “Улаанбаатар аудит ХХК”-иар аудит хийлгэж, аудитын тайланг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэв.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2009.12.29

Тайлангийн хавсралтууд:

- Хавсралт-1. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтын хэрэгжилт /Хуудас-2/
- Хавсралт-2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолын хэрэгжилт (Монгол Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох үндэсний хөтөлбөр) /Хуудас-5/
- **Хавсралт-3.** Мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх болон радио давтамжийн тусгай зөвшөөрлийн судалгаа-2009 он /Хуудас-11/
- Хавсралт-4. ХХЗХ-ны ажилтнуудын гадаад арга хэмжээнд оролцсон судалгаа-2009 он /Хуудас-4/
- Хавсралт-5. ХХЗХ-ны 2008 оны аудитын тайлан /Хуудас-9/